



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 109

Номгон

“Өхэг” ахмадын амралтын газрыг
менежментийн үр дүнг харгалзан уралдаант
төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36, 46, 58 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчид бүртгэлтэй “Өхэг” ахмадын амралтын газрыг менежментийн үр дүнг харгалзан уралдаант төсөл сонгон шалгаруулалтаар хувьчилсугай.

2. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1 Хувьчлах доод үнийг мэргэжлийн үнэлгээчин болон үнэлгээний компаниар зах зээлийн үнэнд нийцүүлэн бодитой тогтоолгосугай.

2.2 Ахмадын амралтын зориулалтыг нь өөрчлөхгүйгээр хууль журмын дагуу ажлын хэсэг байгуулан төсөл сонгон шалгаруулах аргаар зохион байгуулж, хувьчилсан тухай тайлангаа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд III улиралд багтаан танилцуулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117243